



Говь-Алтай аймгийн засаг даргын 2016 оны 9 дүгээр сарын 27-ны А/352 дугаар захирамжаар хүчингүй болсон

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2009 оны 7 дугаар

сарын 17-ны өдөр
204

Алтай

Дугаар

ХУУЛЬ БУС АШИГТ МАЛТМАЛ ОЛБОРЛОХ

ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОГСООЖ, ХЯНАЛТ

ТАВИХ ТУХАЙ

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.5, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1, Газрын хэвлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.5, Усны тухай хуулийн 14 дүгээр бүлгийн 14.1.4 дэх заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг.Аймгийн хэмжээнд гар аргаар хууль бусаар ашигт малтмал олборлож, байгаль орчны тэнцвэрт байдлыг алдагдуулж байгаа иргэдийн үйл ажиллагааг 7 дугаар сарын 16-наас эхлэн бүрэн зогсоож, хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн хэлтэс /Ж.Галбадрах/, Мэргэжлийн хяналтын газар /Ж.Гаваа/, Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Л.Түвд/, бүх сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

Хоёр.Сумынхаа нутаг дэвсгэрт гар аргаар ашигт малтмал олборлуулахгүй байх урьдчилсан зохион байгуулалтын арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн, нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудтай хамтран байгаль, дэлхийгээ хайрлан хамгаалах үзлийг төлөвшүүлэх сургалт сурталчилгааг эрчимжүүлж ажиллахыг сумдын Засаг дарга нарт

үүрэг болгосугай.

Гурав.“Үйл ажиллагааг нь зогсоосноос хойш хууль бусаар ашигт малтмал олборлосон иргэдэд Захиргааны хариуцлагын тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж ажиллахыг аймгийн Мэргэжлийн хяналтын газар /Ж.Гаваа/, Цагдаагийн хэлтэс /Ж.Галбадрах/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

Дөрөв.Гар аргаар ашигт малтмал олборлох явцад эвдэрсэн газруудад нөхөн сэргээлт хийх ажлыг 10 дугаар сарын 15-ны дотор зохион байгуулж, тайлагнаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газар /Л.Түвд/, бүх сумдын Засаг дарга нарт даалгасугай.

Тав.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж хэрэгжилтийг 7 хоног тутамд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Х.Энхбаяр/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.БЯМБАЖАВ